



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 1/311

Арвайхээр

### Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 42 дугаар зөвлөмжийн дагуу Арвайхээр сумын нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтын ажлын 1 дүгээр багц Арвайхээр сумын багуудын нэгдсэн төвийн авто зогсоолыг 33141705 (гучин гурван сая нэг зуун дөчин нэгэн мянга долоон зуун тав), 8 дугаар багц Өндөр гэгээн Занабазарын цэцэрлэгт хүрээлэнгийн авто зогсоолыг 48820962 (дөчин найман сая найман зуун хорин мянга есөн зуун жаран хоёр), 10 дугаар багц Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн багш, ажилчдын орон сууцны дундуурх авто замын засвар шинэчлэлийг 31704568 (гучин нэгэн сая долоон зуун дөрвөн мянга таван зуун жаран найм), 11 дүгээр багц Арвайхээр сумын 1, 9 дүгээр багийн спорт заалны авто зогсоолыг 40797484 (дөчин сая долоон зуун ерэн долоон мянга дөрвөн зуун наян дөрөв) төгрөгөөр Төгс зам ХХК-иар, 2 дугаар багц Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны зүүн талын авто зогсоолыг 19500000 (арван есөн сая таван зуун мянга), 3 дугаар багц Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн авто зогсоолыг 70500000 (далан сая таван зуун мянга), 4 дүгээр багц Энх-Оюу төвийн зүүн болон урд талын авто зогсоолыг 57600000 (тавин долоон сая зургаан зуун мянга), 5 дугаар багц Арвайхээр сумын 20, 40 айлын орон сууцны авто зогсоолыг 31800000 (гучин нэгэн сая найман зуун мянга), 6 дугаар багц Арвайхээр сумын шинэ, хуучин 36 айлын орон сууцны авто зогсоолыг 52300000 (тавин хоёр сая гурван зуун мянга), 7 дугаар багц Арвайхээр сумын 7 дугаар цэцэрлэгийн авто зогсоолыг 23470000 (хорин гурван сая дөрвөн зуун далан мянга), 9 дүгээр багц Арвайхээр сумын 4 дүгээр сургуулийн зүүн талын авто зогсоолыг 95000000 (ерэн таван сая), 12 дугаар багц Арвайхээр сумын төв барааны захын баруун талын авто зогсоолыг 11200000 (арван нэгэн сая хоёр зуун мянга) төгрөгөөр Өвөрхангай АЗЗА ТӨХК-иар тус тус гүйцэтгүүлсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Гүйцэтгэгч аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011100675